

Стефаны үхэл

-The Death of Stephen-



113Page

Тайлбарлагч

Есүс дахин амилсаны дараа дагалдагч нар нь Бурханы үгийг хичээнгүйлэн дамжуулж эхэлсэн. Есүсийн дагалдагч нар Бурханы үгийг дамжуулж эхэлсэнээр итгэгч хүмүүс бага багаар нэмэгдэж байв. Дагалдагч нарт сүмийн ажлыг даалгахын тулд долоон үйлчлэгчийг сонгов. Тэр дунд итгэлийн хувьд маш сайн Стефан гэгч хүн байв. Стефаны нэр нь алдарын титэм гэсэн утгатай байв.



114Page

Тайлбарлагч

Стефанаар дамжуулан Бурханы олон гайхамшигууд бий болсон. Тэр чөтгөрийг зайлуулж, өвчтэй хүнийг эдгээж байв. Тиймээс олон хүмүүс түүнийг дагав.

Өвчтэй хүн1

Стефан гуай, Стефан гуай миний хөл маш их өвдөж байна. Хөлийг маань эдгээгээд өгөөч.

Өвчтэй хүмүүс

Намайг ч эдгээгээд өгөөч! Намайг ч эдгээгээд өгөөч! Ёох ёох (өвдөж шаналж байгаа авиа гаргана.)

Стефан

Бурхан минь, энэ хүмүүсийг өрөвдөн өршөөж эдгээж өгөөч.

Тайлбарлагч

Ингэж залбирахад олон хүн эдгэж байв. . Стефан Бурханы өгсөн мэргэн ухаанаар олон хүнд үгийг дамжуулж тайлбарлаж байв. Түүнийг дагах хүмүүсийн тоо ч ихсэж байлаа.



115Page

Тайлбарлагч

Гэтэл нэгэн өдөр Стефанд атаархаж дургүйцдаг хмүүүс түүнийг Иудейн удирдагч нарт гүтгэн ховлодог.

Хүн1

Стефан хүмүүст Мосе болон Бурханы тухай худал ярьж байна!

Иудейн удирдагч

Юу гэнээ!, Стефаныг хурдан барьж ир!

Хүн1


Стефан Мосе болон Бурханы үгийг зөрчсөн. Бид өөрсдөө газар дээр нь сонссон.

Хүмүүс

Тийм тийм, яг тэгсэн.

Тайлбарлагч

Тэр үеийн Иудейн шашинд Бурханы үгийг эсэргүүцвэл чулуу шидэж алдаг хуультай байлаа. Стефаныг үзэн яддаг хүмүүс Стефанд атаархсандаа энэ үхлээр үхээсэй хэмээн бодсон учраас ингэж барьж өгсөн байлаа. Иудейн удирдагч Стефанаас асуув.



116Page



117Page

- Иудейнууд ирлагч** Энэ хүмүүсийн ярьж байгаа үнэн үү?
- Тайлбарлагч** Стефан хэнээс ч айлгүйгээр маш зоригтойгоор Бурханы үгийг дамжуулж эхлэв.
- Стефан** Та бүхэн миний үгийг сонс. Есүс өөрийн ард түмний төлөө загалмай дээр нас барсан. Та нарын хууль гэм нүгэлгүй Есүсийг алагдахад хүргэсэн.
- Тайлбарлагч** Хүмүүс маш их уурлав. Гэсэн ч Стефан айсангүй.
-
- Тайлбарлагч** Ариун сүнсээр дүүрсэн Стефан тэнгэр өөд ширтэн хараад ингэж хэлэв.
- Стефан** Харагтун, тэнгэр нээгдэж Бурханы баруун талд Есүс сууж байна!
- Тайлбарлагч** Стефаны үгийг сонссон хүмүүс түүнийг доромжлов. Тэгээд түүнийг гадагшаа авч гаран чулуу шидэлж эхлэв.
- Чулуу шидэгч хүн1** Худалч Стефан үх!
- Чулуу шидэгч хүн2** Чи Бурханы нэрийг доромжлогч!
- Чулуу шидэгч хүн3** Чулуунд оногдож үхвэл таарна!
- Тайлбарлагч** Стефан өвдөг сөгдөн залбирав.
- Стефан** Эзэн минь, намайг хүлээн аваач, харин энэ хүмүүсийг уучилж өгөөч.
-
- Тайлбарлагч** Ингээд Стефан амьсгал хураав. Стефан үхэх хүртлээ Бурханы үгийг дамжуулж байлаа. Тэр анхны чуулганы үед Бурханы төлөө амиа зориулсан анхны хүн болсон юм.



118Page